



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Цогт сумын Баянтоорой багийн ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ГАА-2022/88/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Алтай хот
2022 он

Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр

Утас: 70483413 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг

Утас: 70484055 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn

Аудиторын туслах: Ч.Даваасүрэн

Утас: 99559722 Цахим хаяг: daavkach@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	3
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	8
3. Аудитын тайлан	9
3.1 Ерөнхий зүйл	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал	10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	10
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	12
3.8 Аудитын гол асуудал.....	12
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	12
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	12
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	13
4. Аудитын илрүүлэлт	13
4.4 Зөвлөмж	14
1. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	14

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

9018301, Говь-Алтай аймаг,
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
E-mail: govialtai@audit.gov.mn

2022.08.25 № 104

танай _____ -ны № _____ -т

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Цогт сумын Баянтоорой багийн ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Цогт сумын Баянтоорой багийн ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

07020379

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР



2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	94,356,527.11	99,340,543.86
33	АВЛАГА	13,668,690.00	15,318,479.00
335	Бусад авлага	13,668,690.00	15,318,479.00
3351	Байгууллагаас авах авлага	-	1,649,789.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	13,668,690.00	13,668,690.00
35	БАРАА МАТЕРИАЛ	76,183,217.61	79,517,445.36
351	Түүхий эд материал	869,250.00	1,161,850.00
35110	Тусгай зориулалттай материал	869,250.00	869,250.00
35130	Эм боох материал	-	292,600.00
354	Хангамжийн материал	75,313,967.61	78,355,595.36
35410	Бичиг хэргийн материал	15,380,120.00	15,432,120.00
35420	Аж ахуйн материал	21,183,628.21	21,283,028.21
35440	Түлш, шатах тослох материал	9,420,000.00	6,019,000.00
35450	Барилгын засварын материал	240,750.00	345,750.00
35460	Хүнсний материал	-	109,091.00
35470	Бусад хангамжийн материал	29,089,469.40	35,166,606.15
36	НӨӨЦИЙН БАРАА	4,504,619.50	4,504,619.50
36100	Барааны нөөц	4,504,619.50	4,504,619.50
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,348,511,019.09	1,306,152,765.99
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,348,511,019.09	1,306,152,765.99
392	Биет хөрөнгө	1,312,349,852.28	1,270,329,015.95
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,381,637,181.43	1,381,637,181.43
39202	Хуримтлагдсан элэгдэл	(150,028,175.81)	(191,890,467.40)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	8,996,300.00	8,996,300.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(8,996,300.00)	(8,996,300.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	107,163,028.81	117,097,380.81
39206	Хуримтлагдсан элэгдэл	(65,683,376.06)	(72,452,351.66)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	105,903,971.18	105,903,971.18
39208	Хуримтлагдсан элэгдэл	(74,291,594.67)	(78,598,872.72)
39217	Ном	7,648,817.40	8,632,174.31
393	Биет бус хөрөнгө	36,161,166.81	35,823,750.04
39301	Програм хангамж	1,050,000.00	1,050,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(674,833.19)	(1,012,249.96)
39303	Бусад биет бус хөрөнгө	35,786,000.00	35,786,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,442,867,546.20	1,405,493,309.85
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	297,482.00	1,947,271.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	297,482.00	1,947,271.00
413	Өглөг	297,482.00	1,947,271.00
4136	Бусад өглөг	297,482.00	1,947,271.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	284,000.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	297,482.00	1,663,271.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,442,570,064.20	1,403,546,038.85
51	Засгийн газрын хувь оролцоо	1,442,570,064.20	1,403,546,038.85
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	274,186,531.00	274,186,531.00
51101	Өмч: - төрийн	274,186,531.00	274,186,531.00
512	Хуримтлагдсан үр дүн	768,892,034.53	729,868,009.18
51210	Өмнөх үеийн үр дүн	768,892,034.53	768,892,034.53
51220	Тайлант үеийн үр дүн	-	(39,024,025.35)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	399,491,498.67	399,491,498.67
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,442,867,546.20	1,405,493,309.85

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	687,792,955.50	646,311,234.66
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	12,118,734.50	15,168,845.66
120	Нийтлэг татварын бус орлого	12,118,734.50	15,168,845.66
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	12,118,734.50	15,168,845.66
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	14,115.00	
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	12,104,619.50	15,168,845.66
	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө		10,917,708.91
	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал		4,251,136.75
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	675,674,221.00	631,142,389.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	596,079,300.00	583,465,800.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	596,079,300.00	583,465,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	29,444,921.00	6,951,589.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	25,270,020.00	4,433,789.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,174,901.00	2,517,800.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	50,150,000.00	40,725,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	50,150,000.00	40,725,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	775,952,175.33	685,335,260.01
21	УРСГАЛ ЗАРДАЛ	775,952,175.33	685,335,260.01
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	707,919,227.83	645,157,940.81
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	451,973,225.50	441,102,556.15
210101	Үндсэн цалин	376,080,969.50	372,314,373.15
210104	Урамшуулал	34,795,527.00	28,388,857.00
210105	Гэрээт ажлын хөлс	41,096,729.00	40,399,326.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	59,519,707.91	61,476,018.65
210201	Тэтгэврийн даатгал	44,208,833.00	45,293,293.23
210202	Тэтгэмжийн даатгал	1,544,310.91	2,905,251.93
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,641,625.00	3,585,836.35
210204	Ажилгүйдлийн даатгал	911,923.00	880,938.12
210205	Эрүүл мэндийн даатгал	9,213,016.00	8,810,699.02
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	53,069,388.00	41,375,049.00
210301	Гэрэл, цахилгаан	3,449,388.00	3,279,049.00
210302	Түлш, халаалт	49,620,000.00	38,096,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	20,372,450.00	6,892,400.00
210401	Бичиг хэрэг	897,700.00	2,414,500.00
210402	Тээвэр, шатахуун	11,742,200.00	3,363,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,019,050.00	29,700.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	748,800.00	238,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,964,700.00	846,600.00
2105	Нормативт зардал	28,594,139.81	37,254,355.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	692,210.00	1,947,400.00
210502	Хоол, хүнс	26,701,679.81	34,932,105.00

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,200,250.00	374,850.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	992,500.00	1,892,600.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	992,500.00	
210604	Урсгал засвар	-	1,892,600.00
2107	Томилолт, зочны зардал	696,000.00	1,016,000.00
210702	Дотоод албан томилолт	696,000.00	1,016,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,443,450.00	755,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,647,450.00	755,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	576,000.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	220,000.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	81,258,366.61	53,393,962.01
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,540,000.00	
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	478,950.00	118,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	78,239,416.61	53,275,962.01
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	68,032,947.50	40,177,319.20
2132	Бусад урсгал шилжүүлэг	36,541,325.00	23,951,189.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	6,972,412.00	18,351,189.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	25,270,020.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,298,893.00	5,600,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	95,563.00	3,558,940.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,612.00	753,351.00
213404	Нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэн шилжүүлэг	84,951.00	2,805,589.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	31,396,059.50	12,667,190.20
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	31,396,059.50	12,667,190.20
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(88,159,219.83)	(39,024,025.35)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(88,159,219.83)	(39,024,025.35)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	274,186,531.00	399,491,498.67	768,892,034.53	0.00	1,442,570,064.20
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	274,186,531.00	399,491,498.67	768,892,034.53	0.00	1,442,570,064.20
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	274,186,531.00	399,491,498.67	768,892,034.53	0.00	1,442,570,064.20
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	274,186,531.00	399,491,498.67	768,892,034.53	0.00	1,442,570,064.20
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	274,186,531.00	399,491,498.67	768,892,034.53	0.00	1,442,570,064.20
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-39,024,025.35	0.00	-39,024,025.35
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	274,186,531.00	399,491,498.67	729,868,009.18	0.00	1,403,546,038.85

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	687,508,335.00	631,142,389.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	14,115.00	-
120	Нийтлэг татварын бус орлого	14,115.00	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	14,115.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	14,115.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	687,494,220.00	631,142,389.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	596,079,300.00	583,465,800.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	596,079,300.00	583,465,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	41,264,920.00	6,951,589.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	41,264,920.00	4,433,789.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд оиг болсон нэмэлт орлого	-	2,517,800.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	50,150,000.00	40,725,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	50,150,000.00	40,725,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	687,508,335.00	631,142,389.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	687,508,335.00	631,142,389.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	618,851,380.50	590,959,069.80
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	451,973,225.50	441,102,556.15
210101	Үндсэн цалин	376,080,969.50	372,314,373.15
210104	Урамшуулал	34,795,527.00	28,388,857.00
210105	Гэрээт ажлын хөлс	41,096,729.00	40,399,326.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	59,382,110.00	61,476,018.65
210201	Тэтгэврийн даатгал	44,208,833.00	45,293,293.23
210202	Тэтгэмжийн даатгал	1,406,713.00	2,905,251.93
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,641,625.00	3,585,836.35
210204	Ажилгүйдлийн даатгал	911,923.00	880,938.12
210205	Эрүүл мэндийн даатгал	9,213,016.00	8,810,699.02
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	50,139,388.00	37,974,049.00
210301	Гэрэл, цахилгаан	3,449,388.00	3,279,049.00
210302	Түлш, халаалт	46,690,000.00	34,695,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	16,647,350.00	6,546,300.00
210401	Бичиг хэрэг	798,000.00	1,969,000.00
210402	Тээвэр, шатахуун	9,922,200.00	3,363,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,019,050.00	29,700.00
210404	Ном, хэвлэл	96,600.00	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	748,800.00	238,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,062,700.00	946,000.00
2105	Нормативт зардал	24,821,157.00	37,874,046.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	487,500.00	1,639,000.00
210502	Хоол, хүнс	23,133,807.00	35,035,196.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,199,850.00	1,199,850.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	718,300.00	2,717,600.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	718,300.00	720,000.00
210604	Урсгал засвар		1,997,600.00
2107	Томилолт, зочны зардал	696,000.00	1,016,000.00
210702	Дотоод албан томилолт	696,000.00	1,016,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,443,450.00	755,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр		
210802	хураамж	10,647,450.00	755,000.00
210806	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	576,000.00	
2109	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	220,000.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,030,400.00	1,497,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,540,000.00	
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	490,400.00	1,497,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	68,656,954.50	40,183,319.20
2132	Бусад урсгал шилжүүлэг	37,165,333.00	23,957,189.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	7,596,420.00	18,357,189.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	25,270,020.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,298,893.00	5,600,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	10,612.00	3,558,940.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,612.00	753,351.00
213404	Нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэх шилжүүлэг		2,805,589.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	31,481,009.50	12,667,190.20
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	31,481,009.50	12,667,190.20

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	624,190,800.00	610,770,258.80
21	УРСГАЛ ЗАРДАЛ	624,190,800.00	610,770,258.80
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	600,222,800.00	587,113,069.80
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	447,459,000.00	441,102,556.15
210101	Үндсэн цалин	373,691,000.00	372,314,373.15
210104	Урамшуулал	32,976,000.00	28,388,857.00
210105	Гэрээт ажлын хөлс	40,792,000.00	40,399,326.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	65,907,000.00	61,476,018.65
210201	Тэтгэврийн даатгал	46,968,000.00	45,293,293.23
210202	Тэтгэмжийн даатгал	4,642,000.00	2,905,251.93
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,880,000.00	3,585,836.35
210204	Ажилгүйдлийн даатгал	947,000.00	880,938.12
210205	Эрүүл мэндийн даатгал	9,470,000.00	8,810,699.02
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	38,725,000.00	37,974,049.00
210301	Гэрэл, цахилгаан	4,025,000.00	3,279,049.00
210302	Түлш, халаалт	34,700,000.00	34,695,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,554,200.00	4,416,300.00
210401	Бичиг хэрэг	800,000.00	839,000.00
210402	Тээвэр, шатахуун	2,366,000.00	2,363,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	63,200.00	29,700.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	240,000.00	238,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	985,000.00	946,000.00
2105	Нормативт зардал	39,283,500.00	37,874,046.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,639,000.00	1,639,000.00
210502	Хоол, хүнс	36,444,500.00	35,035,196.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,200,000.00	1,199,850.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,720,000.00	2,717,600.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	720,000.00	720,000.00
210604	Урсгал засвар	2,000,000.00	1,997,600.00
2107	Томилголт, зочны зардал	800,000.00	800,000.00
210702	Дотоод албан томилголт	800,000.00	800,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураа	274,100.00	255,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний г	274,100.00	255,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	500,000.00	497,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	500,000.00	497,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23,968,000.00	23,657,189.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	23,968,000.00	23,657,189.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	18,668,000.00	18,357,189.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,300,000.00	5,300,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	624,190,800.00	610,770,258.80
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	583,465,800.00	570,798,609.80
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	583,465,800.00	570,798,609.80
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	40,725,000.00	39,971,649.00
132001	Орон нутгийн төсвөөс	40,725,000.00	39,971,649.00

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	41,179,970.00	6,951,589.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	41,179,970.00	6,951,589.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	15,909,950.00	3,846,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,722,500.00	2,130,000.00
210401	Бичиг хэрэг	-	1,130,000.00
210402	Тээвэр, шатахуун	2,722,500.00	1,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	-	216,000.00
210702	Дотоод албан томилолт	-	216,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,647,450.00	500,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,647,450.00	500,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,540,000.00	1,000,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,540,000.00	
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	1,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	25,270,020.00	3,105,589.00
2132	Бусад урегал шилжүүлэг	25,270,020.00	300,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	25,270,020.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	300,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	84,951.00	2,805,589.00
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	84,951.00	2,805,589.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	41,264,921.00	6,951,589.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	41,264,921.00	6,951,589.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	41,264,921.00	4,433,789.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		2,517,800.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Цогт сумын Баянтоорой багийн Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой зөвлөмж хүргүүлээ.

Аудитыг “Монголиан бизнес рейтинг аудит” ХХК-ний Говь-Алтай салбарын аудиторын туслах Ч.Даваасүрэн гүйцэтгэж, хяналтыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Д.Эрдэнэчимэг, дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Цогт сумын Баянтоорой багийн Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 07 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Ерөнхий боловсролын сургуулийн үлгэрчилсэн дүрэмд заасны дагуу Цогт сумын Баянтоорой тосгоны Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны үндсэн зорилтыг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

“Хөгжлийн чиг хандлага, нийгэм, соёлын үнэт зүйл, хэрэгцээнд нийцүүлэн боловсрол соёл, шинжлэх ухаан, биеийн тамир, спортын бодлогын үр нөлөөг дээшлүүлэн олон талт тэгш хүртээмжтэй, чанартай үйлчилгээг хэрэгжүүлэх замаар оюуны өндөр боловсролтой, ёс зүй, төлөвшилтэй, эрүүл чийрэг, өрсөлдөх чадвартай хүний нөөцийг бэлтгэх, хөгжүүлэхэд оршино”

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Засгийн газрын 43 дугаар тогтоолоор бүх шатны төсөв захирагч нарт төсвийн хэмнэлтийн горимыг мөрдөж ажиллахаар даалгасан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой, данснаас хөрөнгөтэй хасахтай холбоотой зөвлөмж хүргүүлээ.

Дотоод хяналт хариуцсан ажилтан тусгай төлөвлөгөөний дагуу хяналт шалгалтын үйл ажиллагаа явуулж илэрсэн зөрчил дутагдлыг арилгах чиглэл өгч тайлагнан

ажилладаг. Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Цогт сумын Баянтоорой багийн Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогоор сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт орлого 685.0 сая төгрөгөөс 2 хувиар буюу 13.7 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувь буюу 10.9 сая төгрөгөөр тогтоосон.

Төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг АДБОУС 2320-н 13-д заасны дагуу аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзлээ. Гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн тайлангийн нийт орлого 631.1 сая төгрөгөөс 2 хувиар буюу 12.6 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг гүйцэтгэлийн материаллаг байдлын 80 хувиар буюу 10.6 сая төгрөгөөр шинэчлэн тогтоолоо.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Цогт сумын Баянтоорой багийн Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 52.8 хувиар буюу 41.0 сая төгрөгөөр буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, эздийн өмчийн данс, өглөг данс байна. байна.

Авлага дансны үлдэгдэл 15.3 сая төгрөг болж 1.6 сая төгрөгөөр буурсан байна. Авлагын эцсийн үлдэгдэл нь нэр бүхий хүмүүстэй холбоотой цалингийн нөхөн олговор 13.8 сая төгрөг, нэмэлт санхүүжилтийн тооцооны 1.6 сая төгрөгийн авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 80.4 сая төгрөг болж 0.3 сая төгрөгөөр буурсан байна. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 103.1 сая төгрөгийн, үнэ төлбөргүйгээр 0.6 сая төгрөгийн бараа материал бэлтгэж үйл ажиллагаандаа 104.0 сая төгрөгийн материалыг зарцуулжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,659.2 сая төгрөг болж 11.0 сая төгрөгөөр өссөн байна. Тайлант онд хандив тусламжаар үнэ төлбөргүйгээр 10.9 сая төгрөгийн хөрөнгө орлого авсан байна.

Өглөг дансмны үлдэгдэл 1.9 сая төгрөг болж 1.6 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Өглөг нь нэмэлт санхүүжилтаас өгөх баримтаар нотлогдсон зардлын тооцоо байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,399.9 сая төгрөг болж 42.7 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ. Орлого өмнөх оноос 6.5 хувиар буюу 45.1 сая төгрөгөөр буурсан байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй ба тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 726.2 сая төгрөг болсон байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 928.5 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 304.4 сая төгрөгөөр бууруулж, 624.2 сая төгрөгөөр баталжээ. Төсвийн төсөл өмнөх оны батлагдсан төсвөөс өндөр байгаа нь хүүхдийн хоолны зардал (1500 төгрөг) болж өссөнтэй холбоотой байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсөв захирагчийн 5 хөтөлбөрийн хүрээнд 5 арга хэмжээг төсвөөс санхүүжүүлэхээр 624.2 сая төгрөгийн төсөв баталснаас 583.4 сая төгрөгийг улсын төсвөөс 40.8 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 583.4 сая төгрөгийн санхүүжилт, орон нутгийн төсвөөс 40.8 сая төгрөгийн санхүүжилт авч нийт 624.2 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 610.7 сая төгрөгийг зарцуулж 12.7 сая төгрөгийг улсын төсөвт, 0.8 сая төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 610.7 сая төгрөг буюу 97.8 хувьтай байгаа нь цалин хөлс нэмэгдэл урамшууллын зардлыг 6.4 сая төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 4.4 сая төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 0.8 сая төгрөгөөр, хангамж, бараа материалын зардал 0.1 сая төгрөгөөр, нормативт зардал 1.4 сая төгрөгөөр. Бусад урсгал зардал 0.4 сая төгрөгөөр тус тус хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн

бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар Дээд шатны төсвийн захирагчаас 4.4 сая төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос 2.5 сая төгрөг нийт 6.9 сая төгрөгийн санхүүжилтийг авчээ.

Үүнээс хангамж, бараа материалын зардалд 2.1 сая төгрөг, томилолт, зочны зардалд 0.2 сая төгрөг, багаж техник хэрэгслийн зардалд 4.0 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардалд 0.5 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 1.0 сая төгрөгийг зарцуулж улсын төсөвт 1.1 сая төгрөг, орон нутгийн төсөвт буцаан авахаар 1.6 сая төгрөг тус тус төвлөрүүлж үлдэгдэлгүй байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн цахим системд 827.0 сая төгрөгийн 149 мэдээллийг ил тод байршуулахаас 827.0 сая төгрөгийн 149 мэдээллийг ил тод байршуулсан, 140.6 сая төгрөгийн 19 гүйлгээг хугацаа хоцорч мэдээлсэн байна. Мэдээлэл 83 хувь.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ”, “6.4.4. таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг”, “6.4.5. цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” гэсэн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон 3.1 сая төгрөгийн төлбөрийн акт, 85.2 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн. Аудитаар өгсөн шийдвэрийг бүрэн хэрэгжүүлэн ажилласан тухай албан бичиг ирүүлсэн.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараа жилийн аудитаар

- Үндсэн хөрөнгийн бүртгэлд байгаа хөрөнгийн үнэ, шинж чанарт дүн шинжилгээ хийх
- Төсвийн хэмнэлтийн горимыг мөрдөж ажилласан эсэхийг үзэх нь зүйтэй

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар илэрсэн 4.3 сая төгрөгийн зөрчил илэрсэнээс 3.7 сая төгрөгийн зөрчлийг залруулж, 0.6 сая төгрөгийг зөрчил, батлагдсан төсвийг 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар төлөвлөж зарцуулаагүй, авлага барагдуулаагүй зөрчилд албан шаардлага, шилэн дансны мэдээллийг хугацаа хоцроосон зөрчил, аймгийн ИТХ-ын хөрөнгө данснаас хасах шийдвэр хэрэгжээгүй зөрчилд тус тус зөвлөмж хүргүүлээ.

4.1 Залруулсан алдаа

Боловсролын чанарын шинэчлэл төслийн хүрээнд нийлүүлсэн 3.7 сая төгрөгийн хөрөнгийг орлого аваагүй байсныг залруулж орлого авсан.

4.2 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогдоогүй.

4.3 Албан шаардлага

Батлагдсан төсвийг 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар төлөвлөж зарцуулаагүй байгаа нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-т "үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах" заалттай нийцэхгүй бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Татварын тодорхойлолтоорх суутгагчийн хувь хүнд олгосон орлогоос суутгасан татварын 0.5 сая төгрөгийн авлага, хог хаягдлын 0.06 сая төгрөгийн авлага, усны төлбөрийн 0.04 сая төгрөгийн өглөгийг санхүүгийн тайланд тайлагнаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.1-т "Аж ахуйн бүх ажил, гүйлгээ", 14.4.2-т "Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", 14.4.3-т "Бүх өр төлбөр" заалттай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Шүүхийн шийдвэрээр олгогдсон цалингийн 13.6 сая төгрөгийн авлагыг барагдуулаагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь заалт /Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх/, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.1 дахь заалт /Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий

нягтлан бодогч нар хариуцна/ заалттай нийцэхгүй бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ

4.4 Зөвлөмж

Аудитаар илэрсэн алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Шилэн дансны хэрэгжилттэй холбоотой асуудал

- 1.1. Илрүүлэлт: Шилэн дансны цахим хуудсанд 140.6 сая төгрөгийн 19 гүйлгээг хугацаа хоцорч мэдээлсэн. Хэрэгжилтэд тавих дотоод хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.
- 1.2. Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ, 6 дугаар зүйлийн 6.4.4-т "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг; 6.4.5.цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэсэн заалтуудыг мөрдөн ажиллах

2. Данснаас хөрөнгө хасахтай холбоотой асуудал

- 2.1. Илрүүлэлт: Аймгийн ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 27 өдрийн 97 тоот тогтоол "Хөрөнгө акталж данснаас хасахыг зөвшөөрөх тухай" шийдвэр хэрэгжээгүй.
- 2.2. Өгсөн зөвлөмж: Аймгийн ИТХ-ын шийдвэрийг үндэслэн 2022 оны 1-р улиралд хөрөнгө актлах, данснаас хасах ажлыг зохион байгуулах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 07 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитаар зөвлөмж өгөөгүй

1. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Цогт сумын Баянтоорой багийн ерөнхий боловсролын сургууль	6	4.3	1	3.6			3	0.6	2	